



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

### Г Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам” /цаашид “журам” гэх/-д дор дурдсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай:

1/ Журамд дор дурдсан агуулгатай дараах 3.2<sup>1</sup>, 3.9<sup>1</sup>, 4.16, 4.17, 4.18, 4.19, 4.20, 4.21, 4.22 дүгээр зүйлийг нэмсүгэй:

“3.2<sup>1</sup>. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т заасан Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага гэдэгт дараах этгээдийг тооцно.

3.2<sup>1</sup>.1. Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа явуулдаг, уг үйл ажиллагааг тусгайлан хариуцах санхүүгийн алба бүхий хуулийн этгээд;

3.2<sup>1</sup>.2. Интернет, тоон телевиз, телефон ярианы үйлчилгээ үзүүлдэг, эдгээр үйлчилгээнээс бий болох мөнгөн урсгалыг тусгайлан хариуцах санхүүгийн алба бүхий хуулийн этгээд.

3.9<sup>1</sup>. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл хүссэн этгээд нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягт СЗХ05001-ийн дагуу гаргасан өргөдөл, 2 дугаар хавсралтад заасан хавсаргах баримт бичгийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу бүрдүүлж Хороонд цаасаар болон цахимаар ирүүлнэ.

4.16. Хөрөнгө итгэмжлэн удирдах удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн этгээд нь энэхүү журмын 3 дугаар хавсралтаар батлагдсан маягт СЗХ05002-ийн дагуу гаргасан өргөдөл, 4 дүгээр хавсралтад заасан хавсаргах баримт бичгийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу бүрдүүлж Хороонд цаасаар болон цахимаар ирүүлнэ.

4.17. Хороо нь хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 20 хоногийн дотор Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлэнэ.

4.18. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгож, нэгдсэн бүртгэлд бүртгэн, зохих зааврын дагуу хувийн хэрэг нээн хөтөлнө.

4.19. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр олгохоос татгалзана. Үүнд:

4.19.1. хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг зээлийн эх үүсвэрээр бүрдүүлсэн нь нотлогдсон;

4.19.2. хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон;

4.19.3. хувьцаа эзэмшигч нь зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өртэй;

4.19.4. хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтнууд нь гэмт хэрэгт шалгагдаж байгаа болон шүүхийн шийтгэх тогтоолоор ял шийтгэл эдэлж байгаа нь эрх бүхий байгууллагаар тодорхойлолтоор тогтоогдсон;

4.19.5. энэхүү журамд заасан бусад нөхцөл, шаардлагыг хангаагүй.

4.20. Ирүүлсэн баримт бичиг нь шаардлага хангаагүй, нэмж тодруулах шаардлагатай бол Хороо албан бичгээр мэдэгдэж, хууль журмын шаардлагын дагуу нэмж бүрдүүлж ирүүлсэн өдрөөс эхлэн шийдвэрлэх хугацааг тооцно.

4.21. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

4.22. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн үндэслэлээр татгалзсан өдрөөс хойш тухайн хүсэлт гаргагч хуулийн этгээдээс хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг 1 жилийн дотор дахин хүлээн авахгүй.”

2. Журмын 2.8.14-д “Үүсгэн байгуулагчийн сүүлийн 3 жилийн аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан”, журмын 3.4-д “ТЗК-ийг үүсгэн байгуулагч нь сүүлийн 3 жил хэвийн үйл ажиллагаа явуулсан, ...” гэж тус тус заасныг хасах.

3. Журамд холбогдох өөрчлөлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т, Бүртгэл зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭГЛЭГЧ  
ДЭД ДАРГА Э.ВАТБОЛД

